



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө эзэмшүүлж,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороонд байрлах, нийт 12,277,921,098.00 (арван хоёр тэрбум хоёр зуун далан долоон сая есөн зуун хорин нэгэн мянга ерэн найман) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

00000000

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн
27 дугаар тогтоолын хавсралт

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД ЭЗЭМШҮҮЛЖ, БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ХАЛГААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэм жиж нэгж	Тоо шир хэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуриятлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1. Барилга байгууламж								
	Конторын барилга (шинэ барилга, Чингэлтэй дүүрэг, Б. Ширэндэвийн гудамж, 8/4)	2019/12/16	11,116,452,094.00	м.кв	6206	11,116,452,094.00		11,116,452,094.00
2	Гадна бохир усны шугам	2019/12/16	68,351,003.00	метр	220	68,351,003.00		68,351,003.00
3	Гадна цэвэр усны шугам	2019/12/16	92,277,002.00	метр	120	92,277,002.00		92,277,002.00
4	Гадна дулааны шугам	2019/12/16	275,496,537.00	метр	120	275,496,537.00		275,496,537.00
5	Цахилгааны шугам	2019/12/16	3,816,332.00	метр	3	3,816,332.00		3,816,332.00
6	Гадна холбоо	2019/12/16	39,160,453.00	метр	20	39,160,453.00		39,160,453.00
7	Гадна цахилгаан, дэд өртөө	2019.12.16	601,581,356.00	м.кв	40.28	601,581,356.00		601,581,356.00
	Дүн					12,197,134,777.00		12,197,134,777.00
2. Бусад үндсэн хөрөнгө								
8	Явган хүний зам	2019/12/16	6,042,575.00	м.кв	70	6,042,575.00		6,042,575.00
9	Хатуу хучилттай авто зам	2019/12/16	74,743,746.00	м.кв	440	74,743,746.00		74,743,746.00
	Дүн					80,786,321.00		80,786,321.00
	Нийт дүн					12,277,921,098.00		12,277,921,098.00